
An illustration of three children sitting on stacks of books. A girl with blonde hair in a blue shirt sits on a stack of three books on the left. A girl with brown hair in a red dress sits on a stack of three books in the center. A boy with brown hair in a green shirt sits on a stack of three books on the right. The text is overlaid in the center in yellow.

**Орон нутагт тулгамдаж буй  
асуудлыг шийдвэрлэхэд  
хүүхдүүд хувь нэмрээ  
оруулах нь**



## Келвин До

Келвин 1996 онд Африкийн Сиарра Леон улсын хөдөөгийн нэгэн тосгонд төржээ. Түүний өсөж төрсөн орчин дайн дажинд нэрвэгдсэн, ядуу тарчиг байв. Тэрээр 11 настай байхаас бие даан инженерийн ухаанд суралцаж, мөн өөрийн богино долгионы радио ажиллуулж байжээ. Келвин элдэв төрлийн хаягдал, металл эд ангиуд цуглуулж зай, радио дамжуулагч, дуу өсгөгч зэрэг радио ажиллуулахад хэрэгтэй төхөөрөмжүүд зохион бүтээжээ. Эмээ, ээж нь түүнийг хог түүлээ гэж ихэд дургүйцдэг байсан гэдэг.



Түүний хаягдал эд анги ашиглан шинээр бүтээсэн цахилгаан үүсгүүр үндэсний зохион бүтээгчдийн уралдаанд түрүүлж, энэ мэдээ нийгмийн сүлжээгээр тарж, түүний талаар хүн мэдээ нийгмийн сүлжээгээр тарж, түүний талаар хүн болгон мэдэх болжээ. Келвин 16 настайдаа АНУ-ын Харвардын их сургуульд уригдан бүтээлээ танилцуулсан юм. Тэрээр одоо орон нутагтаа өөрийн инженерийн компани байгуулан ажиллуулж, шинэ бүтээгдэхүүн гаргахаар ажиллаж байна.

## ХҮҮХДИЙН ОРОЛЦОХ ЭРХ

Хүн бүр хүний бүхий л эрх, эрх чөлөөг эдлэх эрхтэй бөгөөд эдгээр эрх, эрх чөлөөгөө хэрэгжүүлэхэд нь шаардагдах тэгш боломж, тэгш байдлыг бий болгох үүргийг төр хүлээдэг. Хүүхдийн оролцох эрх нь бусад эрхийнх нь нэгэн адил 18 нас хүртэлх бүх хүнд хамаатай хүний үндсэн эрх бөгөөд дэлхийн хаана ч, хэзээ ч адил, түгээмэл хэрэгжих ёстой, хүүхэд оролцох эрхээ ямар нэг ялгаварлалгүйгээр эдлэх, хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх эрхтэй.





## Оролцоо

Хүүхэд өдөр тутамдаа гэр бүлдээ, сургууль дээрээ, ангидаа, аймаг дүүрэг, нийслэл, үндэсний хэмжээнд болоод бүс нутаг олон улсын хэмжээнд хүртэл тодорхой арга хэмжээг зохион байгуулж оролцож оролцогч болж байдаг бол нөгөө талаас тухайн үйл ажиллагааг зохион байгуулагч оролцуулагч нь болдог





Жишээ нь: Гэр бүлийн хөдөлмөрийн хуваарьт оролцох, гэр бүлийн төсвийн төлөвлөлтөд оролцох, ангидаа бол ангийн даргаа сонгоход оролцох, сургуулийн дотоод дүрэм журмыг боловсруулахад эсвэл төрөл бүрийн үйл ажиллагааг санаачлан анги болон сургуулийнхаа хүүхдүүдийн дунд зохион байгуулах,



# Жишээ



Тиймээс хүүхэд, залуучууд бид өөрсдийнхөө аюулгүй байдлын төлөө юу хийж чадах вэ? Бид энэ бүхний эсрэг юу хийж чадах вэ, бид үе тэнгийхнээ, дүү нараа гэмт хэргийн золиос болохоос хэрхэн сэргийлж чадах вэ?.



# Бие даан ажиллах


Сургууль, орон нутагтаа тулгамдаж буй асуудлыг сайтар бодож хүүхдүүд та бүхэн оролцох боломжтой 3 асуудлыг тодруулаарай



Асуудал 1	Асуудал 2	Асуудал 3	Шалгуур
			Энэасуудлыг шийдвэрлэх нь орон нутгийн хүмүүсийн амьдралд шууд бодитой ач холбогдолтой юу?
			Богино хугацаанд шийдвэрлэх боломжтой юу?
			Хүмүүс сайн мэддэг үү?
			Хүмүүс эмзэглэж, шийдүүлэхийг хүсдэг үү?
			Гарах үр дүн
			Шийдвэрлэхэд гарах мөнгө санхүү
			Хэр хугацаа шаардах вэ?



Сонгож авсан асуудлыг шийдвэрлэхэд хамгийн чухал үүрэгтэй, мөн хамгийн их нөлөө үзүүлж болох хувь хүн, бүлэг, байгууллагуудыг тодорхойлж, зураглал хийгээрэй.





Сонгосон асуудлыг шийдвэрлэснээр тодорхой ямар үр дүнд хүрэх вэ гэдгийг сайтар ярилцаж тодорхойлоорой. Энэ нь зорилгодоо хэрхэн хүрэх аргаа тодорхойлох болон хамтран ажилласны дараа зорилгодоо хүрсэн эсэхээ дүгнэхэд зайлшгүй хэрэгтэй юм шүү.

Хүрэх үр дүн 1	
Хүрэх үр дүн 2	
Хүрэх үр дүн 3	



Эдгээр үр дүнд хүрэхийн тулд хийх ажлууд буюу үйл ажиллагааныхаа стратегийг ярилцаж тодорхойлоорой.

Хүрэх үр дүн 1	
Хүрэх үр дүн 2	
Хүрэх үр дүн 3	



Баярлалаа